

**НИЙСЛЭЛИЙН ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН  
2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**Нэг. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүн**

1.1. Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт

Монгол Улсын Их хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого"-д заасан 10 стратегийн зорилтыг хэрэгжүүлэн ажиллалаа. Гүйцэтгэл тухайн жилийн хүрсэн байх түвшинтэй харьцуулан 93 хувьтай байна.

Бодлого чиглэл	Заалтын тоо	Зорилтын тоо	Хэрэгжилтийн хувь							Дундаж хувь
			100	90	70	50	30	10	0	
5.1. Макро эдийн засгийн бодлого	2	3		3						
5.2. Эдийн засгийн бодит салбаруудын хөгжлийн бодлого	3	7	5	1	1					
<b>Дүн</b>	5	10	5	4	1					<b>93</b>

1.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагаа"-ны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусгагдсан бодлогын 3 чиглэлийн 4 зорилт, 4 арга хэмжээг хяналтад аван хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Бодлого чиглэл	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь							Дүгнэгдээгүй	Хэрэгжилтийн дундаж хувь
			100	90	70	50	30	10	0		
Нэг. Ажилтай, орлоготой монгол хүн	2	2			1	1					60,0
2. Ноос, ноолуур, арьс ширний чиглэлээр хэрэгжүүлэх бодлого	1	1				1					50,0
7. Үйлчилгээний бизнесийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх бодлого	1	1				1					50,0
<b>Дүн</b>	4	4			1	3					<b>55,0</b>

Төлөвлөгдсөн (НЗДТГ-аас зааж өгсөн) нийт арга бүрэн хэрэгжсэн заалт байхгүй, заалтууд хэрэгжих шатандаа 50-70 хувийн биелэлттэй байна.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилт дунджаар 55,0 хувьтай дүгнэгдэв.

1.3. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт

Тайлант хугацаанд үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарт нэг үндэсний хөтөлбөр, хоёр дэд хөтөлбөр хэрэгжиж байна.

№	Хөтөлбөр, төслийн нэр, батлагдсан огноо, шийдвэрийн дугаар	Хугацаа	Хэрэгжилтийн үнэлгээ, хувиар
	Нэг. Мал аж ахуйн салбар		

1	“Монгол мал” дэд хөтөлбөр, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 119 дүгээр тогтоол	2014-2021	10
2	“Нийслэлийн Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөр, НЗД-ын 2014 оны А/451 дүгээр Захирамж	2014-2023	10
Хоёр. Газар тариалангийн салбар			
3	“Чацаргана” хөтөлбөр, ЗГ-ын 2010 оны 60 дугаар тогтоол	2010-2016	87,6

Нийслэлийн хүн амын сүүний хэрэгцээний 80 хувийг дотоодоос хангах зорилтын хүрээнд Нийслэлийн онцлогт тохирсон мал аж ахуй эрхлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр “Монгол мал”, Нийслэлийн “Эрчимжсэн аж ахуйн хөгжлийг дэмжих” зэрэг дэд хөтөлбөр боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

#### 1.4. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарт хамаарах 5 чиглэлээр 8 зорилтыг хяналтад авч, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээнд тусгах замаар хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Төлөвлөгдсөн нийт зорилтууд хэрэгжих шатандаа, гүйцэтгэл дунджаар 52,5 хувьтай байна.

НЗД бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт		Хувь
<i>НЭГ. АГААР ЦЭВЭР УЛААНБААТАР</i>		
<i>1.2 Хөрс болон орчны бохирдлыг бууруулах чиглэлээр:</i>		
1.2.3 Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж буй үйлдвэр, байгууллагыг хотоос гадагш нүүлгэх шат дараалсан арга хэмжээг авна.		50
<i>ХОЁР. АМИНЫ СУУЦТАЙ УЛААНБААТАР</i>		
<i>2.4. Дэд бүтцийн хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр:</i>		
2.4.3 Усны нөөцийн хайгуул судалгааг нарийвчлан хийж, ашиглах боломжит нөөцийг баталгаажуулан, хэмнэлттэй хэрэглээний шинэ тогтолцоог нэвтрүүлнэ.		70
<i>ГУРАВ. АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ УЛААНБААТАР</i>		
<i>3.5. Багануур дүүргийг хөгжүүлэх чиглэлээр:</i>		
3.5.2 “Багануур” үйлдвэр, технологийн паркийн дэд бүтцийг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.		50
<i>3.7. Налайх дүүргийг хөгжүүлэх чиглэлээр:</i>		
3.7.1 Орон нутгийн нүүрс, барилгын материалын түүхий эдийн нөөцийг түшиглэн бүх төрлийн барилгын материал, утаагүй түлшний үйлдвэрүүдийг цогцолбороор байгуулна.		50
3.7.2 Дүүргийн төмөр зам, дэд бүтцийг ашиглан барилгын материалын бөөний худалдаа, ложистикийн төв болгон хөгжүүлнэ.		50
<i>3.8. Эрчимжсэн МАА-н бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр:</i>		
3.8.1. Улаанбаатар хотын сүүний хэрэглээний 80%-ийг дотоодын үйлдвэрлэлээр хангана.		50
3.8.2. Нийслэлийн Сонгино, Бөхөгийн орчмыг гахай, шувуу, загасны аж ахуй эрхлэх бүс болгон хөгжүүлнэ.		50
3.8.3. Нийслэлийн иргэдийн төмс, хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангана.		50
ДҮН		<b>52,5</b>

### **Хоёр. Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үр дүн**

#### 2.1. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт

Тайлант хугацаанд Засгийн газрын таван тогтоолын 16 заалт, Нийслэлийн Засаг даргын 17 захирамжийн 17 заалтыг хяналтад авч хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа. Хяналтад авсан 33 заалтаас 29 нь 100 хувийн, 4 нь 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Хэрэгжилтийн дундаж үнэлгээ 98,7 хувьтай байна.

№	Тогтоол, шийдвэрийн		Заалт тоо	Хэрэгжилтийн хувь						Хэрэгжилтийн дундаж хувь	
	Нэр	Тоо		100	90	70	50	30	0		
1	Засгийн газрын тогтоол		5	16	15	1					99,4
2	НЗД-н захирамж		17	17	14	3					98
	<b>Дүн</b>										<b>98,7</b>

2.2. Нийслэлийн Эдийн засаг, нийгмийн зорилтод тусгагдсан, тухайн байгууллагаас хийж гүйцэтгэх ажлын хэрэгжилт

Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарт хамаарах 5 чиглэлээр 13 зорилтыг хяналтад аван, зорилт бүрийг хэлтсүүдэд хариуцуулан жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээнд тусгах замаар хэрэгжилтийг ханган ажиллалаа. Төлөвлөгдсөн нийт арга хэмжээнээс 2014 оны байдлаар бүрэн хэрэгжсэн 5, 70-90 хувийн биелэлттэй 5 ажил байна. Арга хэмжээнүүдийн хэрэгжилт дунджаар 91 хувьтай дүгнэгдэв.

НЗД бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт	2014 оны зорилтын тоо	Хэрэгжилтийн хувь						Дүгнэх боломжгүй	Дундаж хувь
		100	90	70	50	30	10		
<b>НЭГ. АГААР ЦЭВЭР УЛААНБААТАР</b>									
<b>1.2 Хөрс болон орчны бохирдлыг бууруулах чиглэлээр:</b>									
1.2.3 Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж буй үйлдвэр, байгууллагыг хотоос гадагш нүүлгэх шат дараалсан арга хэмжээг авна.	3	1	1					1	95
<b>ГУРАВ. АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ УЛААНБААТАР</b>									
<b>3.2. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр:</b>									
3.2.1. Зээлийн барьцаа, баталгааны механизмыг хөнгөвчилж, батлан даалтын хуулийг хэрэгжүүлэн нийслэлийн ЖДҮ-ийн төвийн үйл ажиллагааг идэвхижүүлнэ.	3	2						1	100
<b>3.5. Багануур дүүргийг хөгжүүлэх чиглэлээр:</b>									
3.5.2 "Багануур" үйлдвэр, технологийн паркийн дэд бүтцийг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.	1							1	-
<b>3.7. Налайх дүүргийг хөгжүүлэх чиглэлээр:</b>									
3.7.1 Орон нутгийн нүүрс, барилгын материалын түүхий эдийн нөөцийг түшиглэн бүх төрлийн барилгын материал, утаагүй түлшний үйлдвэрүүдийг цогцолбороор байгуулна.	1	1							100
3.7.2 Дүүргийн төмөр зам, дэд бүтцийг ашиглан барилгын материалын бөөний худалдаа, ложистикийн төв болгон хөгжүүлнэ.	1			1					70
<b>3.8. Эрчимжсэн МАА-н бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх:</b>									
3.8.1. Улаанбаатар хотын сүүний хэрэглээний 80%-ийг дотоодын үйлдвэрлэлээр хангана.	2	1	1						95
3.8.2. Нийслэлийн Сонгино, Бөхөгийн орчмыг гахай, шувуу, загасны аж ахуй эрхлэх бүс болгон хөгжүүлнэ.	2		1	1					80
<b>ДҮН</b>	<b>13</b>	<b>5</b>	<b>3</b>	<b>2</b>				<b>3</b>	<b>91</b>

2.3. Нийслэлийн удирдлагаас цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт

Нийслэлийн удирдлагаас цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулан ажиллаж, мэдээ тайланг цаг тухай бүрд нь холбогдох байгууллагуудад хүргүүлж

ажилласан. Өгсөн үүрэг даалгавраас хэрэгжүүлээгүй ажил байхгүй болно. Манай байгууллагад тусгайлан заагдсан үүргийн биелэлт:

- Нийслэлийн хэмжээнд төмс, хүнсний ногоог нөөцлөх агуулах, зоорийн хэвийн нөхцлийг хангуулах, хадлан тэжээл бэлтгэх ажлыг зохион байгуулах

Нийслэлийн хэмжээнд “Улаанбаатар хот орчимд хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулах, төрөлжсөн бөөний болон жижиглэн худалдааны төв шинээр байгуулах, өргөжүүлэх” төслийн үр дүн биелэлтийг хангах зорилгоор ҮХААЯ, УМХЕГ болон НМХГ-тай хамтарсан шалгалтыг 8 дүүрэгт “Нийслэл дэх төмс, хүнсний ногооны зоорины үйл ажиллагаа, ашиглалт болон энэ жилийн ургац хадгалалт, нөөцийн бэлэн байдлыг хангах цаашид ашиглалтыг сайжруулах боломж нөөцийг судлах багтаамж хүрэлцээг нэмэгдүүлэх” удирдамжийн дагуу явуулж, нийслэлийн хэмжээнд төмс, хүнсний ногоо хадгалах зориулалттай өрхийн хэмжээний 2894 тн багтаамж бүхий 216 зоорь, 59 аж ахуйн нэгж, иргэний нийт 44933 тн-ийн багтаамж бүхий 110 төвлөрсөн зоорь байна гэсэн судалгааг гаргасан. /нийт 47827 тн багтаамжтай/. Энэ нь нийслэлийн хүн амын төмс, хүнсний ногооны жилийн хэрэгцээний 33,03%-ийг хадгалах боломжтой байна.

- Нийслэлд өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн 6 дүүрэгт хүргүүлэн, ажлын чиглэл өгч ажиллаж байна.

Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг бүрэн хангуулах зорилгоор Засгийн газрын 2014 оны 241 дүгээр тогтоол, Үйлдвэр хөдөө аж ахуйн яамны сайдын 01 албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын 04 дүгээр албан даалгаврыг гаргуулан, нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн 6 дүүрэгт хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавьж, өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангасан байдалтай танилцаж үнэлэлт, дүгнэлт өгч ажиллалаа. Нийслэлийн мал сүрэгт 2014-2015 оны өвөл, хаврын улиралд шаардагдах өвс, тэжээл, давс хужирын тооцоог дүүрэг бүрээр гаргаж, малчин болон мал бүхий иргэдээр хадлан тэжээл бэлтгүүлэх үүрэг чиглэлийг өгч, энэ дагуу мэдээ, тайланг авч холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Мал өвөлжилтийн бэлтгэл хангасан дүн мэдээнээс харахад Нийслэлийн хэмжээнд 2014-2015 оны өвөл 329.0 мянган мал өвөлжих судалгаа гарлаа. Нийслэлийн хэмжээнд 7856,5 тонн өвс хадлан, 1962 тонн давс хужир, 432 тн гар тэжээл бэлтгэсэн дүн мэдээтэй байна. Нийслэлийн хэмжээнд өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан ажил 80 хувьтай байна.

- Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа мал, тэжээвэр амьтдын 2014 оны тооллогыг зохион байгуулах.

Нийслэлийн Засаг даргын А/965 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа, мал, тэжээвэр амьтдын тооллогыг Нийслэлийн статистикийн газар, дүүрэг, хороодын Засаг дарга нар, болон хэсгийн ахлагчид, тоологчидтой хамтран 2014 оны 12 дугаар сарын 05-аас 15-ны хооронд зохион байгууллаа.

#### 2.4. Иргэдийн өргөдөл, санал, гомдлын шийдвэрлэлт

1. 2014 оны жил эцсийн байдлаар манай газарт
  - Хүсэлт 64
  - Гомдол 10, нийт 74 өргөдөл хүсэлт ирсэн байна.
  - Цахим системд бүртгэгдсэн 74, хуулийн хугацаанд хариу өгсөн 69, хугацаа хэтэрч хариу өгсөн 5, хугацаандаа байгаа өргөдөл байхгүй байна.

2. Өргөдөл гомдлын хандалтын байдал:
  - 1200 тусгай дугаарын утсанд 6
  - [www.ub1200.mn](http://www.ub1200.mn) цахим хуудсаар 0
  - Засгийн газрын 11 11 төвд хандсан 11
  - Иргэд хүлээн авах төвөөр дамжин ирсэн 5
  - Байгууллага 52 өргөдөл тус тус цахим системд бүртгэгдсэн байна.
3. Өргөдөл гомдлын шат дамжлагыг дурьдахад:
  - Цахим системээр ирсэн өргөдлийг хэвлэн удирдлагад танилцуулна.
  - Удирдлагын цохолтын дагуу холбогдох хэлтсийн даргад цахимаар шилжүүлнэ.
  - Хэлтсийн дарга нар холбогдох мэргэжилтэндээ цохож шилжүүлнэ.
  - Мэргэжилтэн өргөдлийн хариуг удирдлагад танилцуулна.
  - Тухайн өргөдлийг эзэнд албан бичгээр эсвэл утсаар болон бусад байдлаар танилцуулна гэсэн үе шаттайгаар явагдаж байна.
4. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацаа:
  - Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 17 хоног 15 цаг 6 минут байна.
5. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх чиглэлээр хийсэн ажил:
  - Өргөдөл гомдлын цахим системийг шинээр орсон албан хаагчдад нэвтрэх эрх үүсгэж, зааварчилгаа өгч ажиллаж байна. Нийт 36 албан хаагчдад нэвтрэх эрх үүссэн байна.
  - Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хийж байна.

#### 2.5 Архив, албан бичгийн шийдвэрлэлтийн талаар

- Сар бүрийн сүүлийн өдөр хариутай бичгийн шийдвэрлэлтийн мэдээнд хяналт тавьж ажиллалаа. 2014 оны байдлаар нийт 515 бичиг бүртгэн авч, хариутай 342 бичгээс 338 бичгийг хугацаанд шийдвэрлэж, 4 бичгийг хугацаа хэтэрч шийдвэрлэсэн.
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тоон тайлан мэдээг Нийслэлийн архивын газрын зааврын дагуу хагас, бүтэн жилээр гаргаж явууллаа. Оны эхний хагас жилийн байдлаар байгууллага дээр байгаа архивын мэдээг Нийслэлийн архивын газарт цахимаар хүргүүллээ. Байгууллагын архивт бүртгэлтэй байгаа хадгаламжийн нэгжийг эхний хагас жилийн байдлаар бүртгэлийн дагуу тооллого явуулсан.
- Архивын баримт түр олгох бүртгэлийг шинээр үйлдэн заавар журмын дагуу ашиглаж байна. Архивын хадгаламжийн нэгжийг захиргааны хэлтсийн өрөөнд шилжүүлэн, төмөр шүүгээнд байршуулсан. Хадгаламжийн нэгжийн эрэлт хайлтыг шуурхай болгох үүднээс шүүгээ, тавиур, хадгаламжийн нэгж тус бүрийг дугаарлаж, баримт ашиглалтын зөвлөмж гаргасан. Хадгалалтыг сайжруулах үүднээс сан хөмрөгийн чийг, дулаан хэмжих, цэвэрлэгээ үйлчилгээ хийх график гарган графикийн дагуу ажиллаж байна.
- Байгууллагын албан хаагчдын баримт албан хэрэг хөтлөлт, монгол хэл бичгийн дүрмийн чадварыг сайжруулах, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Баримт бичгийн стандарт аян”-ыг санаачилан 2 үе шаттайгаар зохион байгуулсан. Тус аяны хүрээнд албан хаагчдын мэдлэг сорих тест авч сорилыг хариуг албан хаагч бүрт нэг бүрчлэн танилцуулан, албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандартын сургалт явуулсан. Баримт бичгийн стандартад өдөр тутам хяналт тавьж байна.

- Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/452 дугаар "Захирамжлалын баримтад цахим хувь үйлдэх" захирамжийн дагуу 1978-1996, 2005-2013 онуудад гарсан газрын даргын тушаалуудыг цахим хэлбэрт шилжүүлэн нэгдсэн баазад оруулж, 2014 оны 9 дүгээр сард Нийслэлийн архивын газарт хүлээлгэн өгсөн.
- НИТХ-аас баталсан "Ухаалаг Улаанбаатар" хөтөлбөр, НЗД-ын 2014 оны А/237 захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн өөрөө удирдах байгууллага болон Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэрийн нэгдсэн санг хөтлөн эрхлэх журам"-ын хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллагаас 2005-2013 онуудад гарсан 411 захирамжлалын баримт бичигт ангилал, өөрчлөлт /кодификаци/ хийж, гүйцэтгэлээ. Кодификаци хийсэн 2005-2013 онуудын захирамжлалын баримт бичгийг сканердаж байгууллагын цахим хуудаст орууллаа.

## 2.6. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээлэл

- Эмээлтийн шинэ суурьшлын бүсийн цэвэр усны хайгуул судалгааны ажлын даалгаврыг 2014 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Байгаль орчин ногоон хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч нараар хамтран батлуулан Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт 03 дугаар сарын 24-ний өдрийн 05/134 тоотой хүргүүлсэн. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас зарласан "Усны эрэл хайгуулын ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт 4 компани оролцохоор тендерийн бичиг баримтыг бүрдүүлэн ирүүлснээс үнэлгээний хорооны 07 дугаар сарын 03-ны өдрийн хурлаар "Гранд электро техноком", "Охь ус" ХХК-иудын түншлэл шалгаран ажлыг гүйцэтгэж байна. Одоогийн байдлаар 8 ширхэг мониторингийн цооног өрөмдөхөөс 4-ийг, 5 ширхэг худаг өрөмдөхөөс 2-ийг нь бүрэн өрөмдөж дуусаад байна. Мөн 120 цагийн шавхалт-туршилтын ажил, 48 цагийн сэргэлт хэмжилтийн ажил, маршрут-ажиглалтын судалгааны ажил 100%, гадаргуугийн геофизикийн судалгааны ажил 70% гүйцэтгэлтэй байна.
- Инженерийн хийцтэй худгийн техникийн даалгавар, тендерийн баримт бичгийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газартай хамтран боловсруулж, Нийслэлийн Засаг даргын 2014 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/154 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдан, тендерт 7 компани оролцохоор тендерийн бичиг баримтыг бүрдүүлэн ирүүлснээс "Монтегео" ХХК шалгарч, гэрээ байгуулан, дараах 10 байршилд инженерийн худаг гаргаж, холбогдох байгууллагад хүлээлгэн өгсөн. Үүнд:
  - Багануур дүүрэг:
    - 4-р хороо Нүхэн зараа амны эхэнд,
    - 1-р хороо Нарийны ам Нарангийн хойд ухаа
  - Баянзүрх дүүрэг:
    - 20-р хороо Улиастай Баянголын ам
    - 20-р хороо Шар хоолой Халзангийн ам
  - Налайх дүүрэг:
    - 3-р хороо Хөндлөнгийн Давааны ар
  - Сонгинохайрхан дүүрэг
    - 21-р хороо Хужирын хяр,
    - 21-р хороо Мухарын ам дунд хэсэг
    - 21-р хороо Нарийны амны эх Жарын хоолой
  - Хан-Уул дүүрэг:
    - 13-р хороо Булгийн тохой,
    - 12-р хороо Өлийн ам

## Гурав. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн

Төсвийн ерөнхийлөн захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээнд эхний хагас жилийн байдлаар тусгагдсан 11 зорилтын хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлж, тайланг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв. Дундаж гүйцэтгэл 97,1 хувьтай байна.

Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь						Дүнгэдгүй	Хэрэгжилтийн дундаж хувь
		100	90	70	50	30	10		
1.МУ-ын Засгийн газрын шийдвэрийн дагуу арьс шир, ноос ноолуурын анхан шатны боловсруулах үйлдвэрүүдийг хотоос нүүлгэн шилжүүлэх ажлыг ҮХАА-н яамтай хамтран эхлүүлнэ	9	6	1	2					92.2
2.ХУД-ийн 13-р хороо, СХД-ийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр, шинэ суурьшлын бүсэд байгуулах ҮТП-ийн талаар санал боловсруулж, парк байгуулах асуудлыг үе шаттайгаар эхлүүлнэ.	16	12	1	1	2				91.2
3.Туул голын дагуу ашигт малтмал хайх, олборлох тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, нөхөн сэргээлтийг хийлгүүлнэ.	3	3							100
4.Тоосгоны шаврын орд ашиглагч ААН-үүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж, суурьшлын бүсэд үзүүлэх орчны нөлөөллийг бууруулах арга хэмжээг авна.	6	6							100
5.Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилгыг ханган ажиллана.	2	2							100
6.Эмээлтийн шинэ суурьшлын бүсийн цэвэр усны хайгуул судалгааны ажил хийнэ.	7	7							100
7.Төрийн бус байгууллагуудтай хамтран “Үйлдвэрлэл эрхлэгчдийн техник технологийн үзэсгэлэн 2014”, Олон улсын 7-р форум зохион байгуулна.	16	16							100
8.БНХАУ-ын Вэнжүгийн "China International Industry Exhibition 2014" үзэсгэлэнд аж нэгж байгууллагуудыг зохион байгуулж оролцоно.	8	6	2						97.5
9."Багануур" үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.	6	3	3						95
10.Налайх дүүргийн үйлдвэрлэл, технологийн паркийн ТЭЗҮ боловсруулж дуусгана.	21	16	3	1				1	92.4
11.Барилгын материалын үйлдвэрлэл, бөөний худалдаа, ложистикийн төв байгуулах ажлыг зохион байгуулна.	7	7							100
12.Улаанбаатар хотын үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн төлөвлөлтийг хийнэ	3	1	2						93.3
13.Бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах	4	2	1	1					90
14.Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг Жижиг дунд үйлдвэрлэлийн зээлд хамруулах ажлыг зохион байгуулна.	33	27	4	1	2				97,9
15.Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан байгуулж, малыг ээмэгжүүлнэ.	28	26	2						99.3
16.Гахай, шувууны аж ахуй эрхлэх хүсэлтэй иргэд, аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана.	5	5							100
17.Загасны аж ахуй эрхлэх хүсэлтэй иргэдэд дэмжлэг үзүүлнэ.	3	2			1				83.3
18.ХАА-н салбарын ажилтнуудыг шагнаж урамшуулна.	5	5							100
19.ХАА-н усан хангамжийг сайжруулах зорилгоор инженерийн хийцтэй худаг гаргуулна.	7	7							100
20.Тариалалт болон ургац хураалтын бэлтгэл байдлыг хангуулах, хэрэгжилтийн явцад хяналт тавин ажиллана.	5	5							100
21.Газар тариалангийн технологийн сургалтууд зохион байгуулна.	6	6							100
22.Хүнсний ногооны зоорины багтаамжийн нэмэгдүүлэхэд хамтран ажиллана.	2	2							100
23.Хэрэглэгчдийг хямд үнэтэй эх орны хөрсөнд ургасан хүнсний ногоогоор хангахад чиглэсэн ажил үйлчилгээзохион байгуулна.	2	2							100



24. Хүлэмжийн аж ахуй үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	4	4							100
25. Жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлнэ.	4	4							100
26. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг нэмэгдүүлнэ.	3	3							100
27. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын 2013 оны үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээний НУЗ-өөс гаргасан шийдвэрийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж ажиллана.	1	1							100
Дүн									97,1%

### Дөрөв. Дүрмээр хүлээсэн үүргийн биелэлт

#### **3.2.1 Монгол Улсын Засгийн газрын болон нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн тухайн жилийн зорилтод нийслэлийн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлогыг тусгуулан батлуулж, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн ажлыг зохион байгуулах**

2014 онд үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заагдсан 3 чиглэлийн 4 зорилт, 4 арга хэмжээ, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 8 чиглэлээр 12 зорилтыг хэрэгжүүлэх ажлын зохион байгуулж ажиллалаа.

- Улаанбаатар хотын зүүн талд ачаа тээврийн нэгдсэн ложистик байгуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг Нийслэлийн Засаг даргын 2014 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/178 дугаар захирамжаар байгуулж, шийдвэрлэх асуудал, гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулан ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Ажлын хэсгээс гаргасан саналын дагуу газрын төлбөр болон холбогдох асуудлыг шийдвэрлүүлэхээр НИТХТ-ийн хуралд өргөн бариад байна.
- Монгол Улсын Засгийн газар болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн хөрөнгө оруулалтын 2014-2018 оны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2014 оны зорилт, 2014 оны төсвийн төсөлд хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулан батлуулсан.
- Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагатай уялдуулан 2015 оны эдийн засаг, нийгмийн зорилт болон төсвийн төсөлд үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх хүрээнд хэрэгжүүлэх саналыг хүргүүлээ.
- Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах, бэлтгэл ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн парк”, “Налайхын Барилгын материалын Үйлдвэрлэл, технологийн парк” Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрууд байгуулах тухай НИТХТ-ийн 2014 оны 148, 149 дүгээр тогтоолуудыг тус тус батлуулж, бүтэц, орон тоог Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлууллаа.
- Нийслэлд мал аж ахуйн салбарыг эрчимжүүлэн хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор дараах бодлогын баримт бичгүүдийг боловсруулж, батлуулан, төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
  - Нийслэлийн “Монгол мал” дэд хөтөлбөр



- “Нийслэлийн эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөр
- “Нийслэлд мал аж ахуй эрхлэх журам”
- “Мал аж ахуйн хоршоодын үйл ажиллагааг дэмжих” журам
- “Нийслэлийн мал хамгаалах сан”-гийн журам

### **3.2.2 Нийслэлийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан үйлдвэржүүлэлт, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалантай холбоотой төсөл хөтөлбөр, түүний зураг төсөл, техникийн даалгаарыг хянаж санал оруулах**

- НЗД-ын 2014 оны 01 сарын 03-ны өдрийн А/03 тоот захирамжаар үйлдвэрлэл, технологийн паркийн бүсийн усны нөөцийн хайгуулын судалгаа хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог байгуулсан.
- Эмээлтийн шинэ суурьшлын бүсийн цэвэр усны хайгуул судалгааны ажлын тендерт 4 компани оролцохоор тендерийн бичиг баримтыг бүрдүүлэн Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт ирүүлж, тендерийн үнэлгээний хорооны 2014.07.03-ны өдрийн хурлаар "Усны эрэл хайгуулын ажил"-ын гүйцэтгэгчээр "Гранд электро техноком", "Охь ус" ХХК-иудын түншлэл шалгарч ажиллан, ажлын гүйцэтгэлээ БОЯ-ны усны нөөцийн зөвлөлд 2014.12.30-нд хүлээлгэн өгсөн. НЕТГазар, НХОГазраас 2014.01.09-ны өдөр газар дээр нь танилцаж тайланг хүлээн авахад бэлэн болоод байна.
- “Нийслэлийн эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ҮХААЯ-аас “Сүүний чиглэлийн 50, 100, 300 үхрийн цогцолбор аж ахуй”-н зураг төслийг хүлээн авч, 50 үнээний цогцолбор ферм байгуулах газрын ерөнхий байршлыг Сонгинохайрхан дүүрэг Нарийны ам, Хан-Уул дүүрэг Гавжийн шанд, Баянзүрх дүүрэг Бага дэндийн аманд төлөвлөж, энэ хүрээнд төлөвлөлт хийгдэх дүүргүүдээс кадастрийн зураглал хийх саналыг авч, НӨХГ-тай хамтран ажиллах саналыг боловсрууллаа.
- Цогцолбор ферм байгуулах ажилд дэмжлэг авахаар холбогдох саналыг тусгасан Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, төсөлд шаардлагатай мэдээ, судалгаа, танилцуулгыг бэлтгэн, төслийн саналыг ҮХААЯ-нд, фермийн дэд бүтцийн асуудлыг шийдвэрлүүлэхээр хүсэлтийг ЭЗХЯ-нд тус тус хүргүүлээд байна.
- МУ-ын ЗГ-ын 226-р тогтоолын хүрээнд өндөгний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр 2016 онд бүрэн хангах зорилт тавьж, Нийслэлийн дүүргүүдэд 25000 өндөглөгчтэй тахианы цогцолбор загвар аж ахуй байгуулах ТЭЗҮ-г “ЭГЭ”ХХК-аар хийлгэн хүлээн аваад байна. Батлагдсан гахай, тахианы фермийн зураг, төсвийн дагуу сонирхсон иргэд, аж ахуйн нэгжүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөлгөө өгч ажиллаж байна.
- Нийслэлд хөргөлтийн танктай 38 цогц ферм байгуулах саналыг Үйлдвэр, хөдөө аж ахуй яаманд хүргүүлэн энэ ажлын хүрээнд “Сүү боловсруулах цех”-ийн ТЭЗҮ-г ҮХААЯ-аас хүлээн аваад байна.

### **3.2.3 Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан үйлдвэржүүлэлт, хөдөө аж ахуйн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулна**

- Налайх дүүргийн үйлдвэр технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд шаардагдах 180,0 /нэг зуун наян/ сая төгрөгийг Нийслэлийн Засаг Даргын 2014 оны 09 сарын 26-ны өдрийн А/836 дугаар захирамжаар батлуулсан.

- Эмээлтийн шинэ суурьшлын бүсийн цэвэр усны хайгуул судалгааны ажилд 300,0 сая төгрөгийг Нийслэлийн Засаг даргын 2014.04.04-ны өдрийн А/238 тоот захирамжаар батлуулав.
- ХУД-ийн 13 дугаар хороо Эмээлтийн шинэ суурьшлын бүсийн судалгаа төлөвлөлтийн ажилд 150 сая төгрөгийг зарцуулахаар төсөвт тусгаад байна.
- Нийслэлд инженерийн хийцтэй 10 ширхэг худаг шинээр гаргахад шаардагдах 16 957 500 төгрөгийг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/54 дугаар захирамжаар Үнэлгээний хороо байгуулагдан тендерт “МОНТЕГЕО” ХХК шалгарч Багануур дүүрэгт 2, Баянзүрх дүүрэгт 2, Хан-Уул дүүрэгт 2, Сонгинохайрхан дүүрэгт 3, Налайх дүүрэгт 1 гүн өрмийн худаг тус тус гаргаад байна.
- Сүү бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор сүү хөргөх, хадгалах, тээвэрлэх зориулалт бүхий иж бүрэн хөргөлтийн төв байгуулах хүрээнд “АПУ” ХХК нь сүүний фермер эрхлэгчидтэй гэрээ байгуулан ажиллаж 5 тн-ы багтаамжтай хөргүүрийн танкийг Жаргалант тосгон, Улиастайн фермерийн аж ахуйд суурилуулан холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

### **3.2.4 Нийслэлийн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарын мэдээллийн санг бүрдүүлж, түүний баяжилтыг тогтмолжуулна**

- Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 67409 аж ахуйн нэгж, байгууллагын 70 хувь нь Улаанбаатар хотод байршиж байгаа бөгөөд 35788 нь жилийн турш идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаагаас 3000 гаруй боловсруулах үйлдвэр, цехэд 47500 орчим хүн ажиллаж байна.
- Нийслэлийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлтийн 59.3 хувийг уул, уурхай олборлох, 1.1 хувийг боловсруулах, 9.6 хувийг цахилгаан, дулаан, эрчим хүчний аж үйлдвэр эзэлж, 2013 онд оны үнээр нийт 4852.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн нь 2012 онтой харьцуулбал 56.3 хувиар өссөн. Улаанбаатар хотын үйлдвэрүүдийн мэдээг үйл ажиллагаа явуулж байгаа салбаруудаар урьдчилсан байдлаар нэгтгэн гаргаж мэдээллийн санд бүртгэлтэй үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн судалгааг шинэчлэн, байршлыг нарийн тодорхойлж, хуучин судалгаатай тулгах ажлыг хийж байна.
- Нийслэлийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлтийн 59.3 хувийг уул, уурхай олборлох, 1.1 хувийг боловсруулах, 9.6 хувийг цахилгаан, дулаан, эрчим хүчний аж үйлдвэр эзэлж, 2013 онд оны үнээр нийт 4852.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн нь 2012 онтой харьцуулбал 56.3 хувиар өссөн байна.
- НҮХААГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу хүлэмжийн аж ахуй, төмс, хүнсний ногоо, чацаргана жимс, жимсгэнэ ашигт таримлыг тариалсан иргэд, аж ахуйн нэгжийн судалгааг шинэчилсэн.
- Сүүний эрчимжсэн 172 аж ахуйн 6930 үхэр, гахайн 7 аж ахуйн 15997, тахианы 18 эрчимжсэн аж ахуйн 346793 толгой өндөглөгч тахиаг бүртгэж нэгдсэн судалгааг баяжууллаа.
- Мал бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж нийт 106.300 малыг ээмэгжүүлж бүртгэлжүүлэн, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 30.000 малын мэдээллийг оруулж, баяжилт хийгээд байна.

**3.2.5 Иргэдийн оролцоо, санал хүсэлтэд тулгуурлан үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарт ашиглах дотооддоо үйлдвэрлэх боломжгүй техник, сэлбэг, тоног төхөөрөмж, эрдэс бордоо, ургамал хамгааллын бодис, таримал ургамлын шинэ сортын үр, суулгац, өндөр ашиг шимт үржлийн мал, амьтан, тэдгээрийн үр хөврөл, үрийг импортын татвар болон нэмэгдсэн өртгийн татвараас хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх**

- Импортоор оруулж байгаа хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, гурилын үйлдвэрийн болон усалгааны тоног төхөөрөмж, ойн аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд гаалийн албан татвараас тус тус чөлөөлөхөөр гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль гарсан.
- 2014 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн Монгол Улсын Засгийн газрын 191 дүгээр тогтоолоор Гаалийн албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд чөлөөлөгдөх жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалтыг шинэчлэн баталсан.

**3.2.6 Үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарт олгосон гадаадын зээл тусламжийн хөрөнгийг нийслэлийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зорилгод ашиглах асуудлыг холбогдох дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэн зохицуулах**

Үйлдвэр хөдөө аж ахуйн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулан БНХАУ-д үйлдвэрлэсэн хөдөө аж ахуйн зориулалттай бага оврын 25 м.х чадалтай газар тариалангийн 40 иж бүрэн 106 тракторыг нийслэлийн иргэн, аж ахуйн нэгжид 3 жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээлд хамруулаад байна.

**3.2.7 Улаанбаатар хотын хөгжил, эрэлт хэрэгцээнд нийцсэн ажлын байрыг бий болгох арга хэмжээг төрийн захиргааны төв байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх**

- “Налайхын Барилгын материалын Үйлдвэрлэл, технологийн парк” Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар, “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн парк”, “Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газруудыг байгуулж ашиглалтад оруулснаар нийт 6700 орчим ажлын байр шинээр нэмэгдэх юм.
- Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаанд нийслэлийн оролцоог нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох ажлын хүрээнд “Зээлийн батлан даалтын сан”-тай санал солилцох уулзалтыг зохион байгуулж, хамтран ажиллах “Гэрээ”, “Санамж бичиг” байгуулах талаар зөвшилцөн, хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулсан. “Хамтран ажиллах гэрээ”-ний төслийг 2014 оны 05 дугаар сарын 14-ний Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.

**3.2.8 Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг үйлдвэрийн газруудад Монгол Улсын хууль тогтоомж, норм норматив, дүрэм, журмын дагуу үйл ажиллагаагаа явуулахад нь арга зүйн зөвлөгөө өгөх, хэрэгжилтийг хангуулж, гарсан зөрчлийг арилгах асуудлыг холбогдох байгууллагуудад нь уламжилан, хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлүүлэх**

- Байгаль орчинд халгүй үйлдвэрлэл эрхлэх нийтлэг журмын төслийг боловсруулах ажлын хэсгийг НЗД-ын 2014 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/177 дугаар захирамжаар байгуулсан. Журмын төсөлд холбогдох Төрийн захиргааны төв байгууллагууд, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд, Мэргэжлийн холбоодоос саналуудыг авч тусгасан. “Хүрээлэн буй орчинд ээлтэй үйлдвэрлэл эрхлэх нийтлэг журам”-ын төслийг Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн 2014 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд гишүүдийн саналыг тусган дахин хэлэлцэхээр тогтсон. Нийтээр дагаж мөрдөх журмыг үйлдвэрлэлийн бүсийн төлөвлөлт, дүүргүүдэд үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл, Улаанбаатар хотын нэгж хорооллуудын төлөвлөлттэй уялдуулан боловсруулахтай холбогдуулан хамтран ажиллах хүсэлтийг НЕТГазарт хүргүүлээд байна.
- Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага баримт бичигт СХД-ын 6,7,8,11,23 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх “Найрамдлын шар шаврын орд” орчмыг ногоон байгууламж бүхий бүс байгуулахаар тусгагдсан. Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдан удирдамжийн дагуу СХД-ын 6, 7, 8, 11, 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 9 аж ахуйн нэгжид хяналт, шалгалтыг явуулсан. Нийслэлийн Засаг даргын 2014 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/970 дугаар албан тоотоор 2015 он хүртэл үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн мэдэгдэл хүргүүлэн ажиллаж байна.
- Налайх дүүргийн нутаг дэвсгэрт хууль бусаар нүүрс олборлож байгаа аваар осол гарах аюултай ам, цооногуудад хэсэгчлэн хяналт шалгалтыг холбогдох газруудтай хамтран явуулсан. Эхний ээлжинд төмөр зам орчимд олборлолт явуулж байгаа амуудад хяналт шалгалтыг явуулж, нөхөрлөл байгуулаагүй, бэхэлгээ, агааржуулалт муу, далд уурхайн аюулгүй ажиллагааны нөхцлийг хангаагүй амуудын тог цахилгааныг хязгаарлах, аваар осол гаргах аюултай амуудыг өөрсдөөр нь дарж булуулах, аваар ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэдийг 2014 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс 8 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд хууль бусаар олборлолт явуулах, шинээр малталт хийх зэрэг үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон Налайх дүүргийн Засаг даргын 47 дугаар захирамж гарган ажилласан. Мөн нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Налайх дүүргийн Засаг даргын тамгын газар, *Швейцарийн хөгжлийн агентлаг*, *Уул уурхайн алба хамтран 2 удаагийн сургалтыг* зохион байгуулсан. Сургалтанд 120 гаруй уурхайчид хамрагдсан. Одоогоор 150 гаруй ам ажиллаж байна.
- Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/178 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор НМХяналтын газрын даргын баталсан удирдамжийн дагуу НМХГ болон бусад холбогдох газруудтай хамтран Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 14 ачаа тээврийн терминалуудын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг 04-р дүгээр сарын 9-30-ны өдрүүдэд явуулж, шалгалтын дүнг Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хуралд танилцууллаа. Ачаа тээврийн терминалуудыг хотоос нүүлгэн шилжүүлэх асуудлыг НИТТХ-аар хэлэлцүүлэхээр болж, нүүлгэн шилжүүлэхтэй холбогдуулан байгууллагуудад сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулахаар шийдвэрлэсэн.
- Нийслэлийн Засаг даргын 2013 оны 479 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор НЗД-ын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнэ даргын баталсан удирдамжийн дагуу “Төв болон урьдчилан цэвэрлэх байгууламжид бохир ус нийлүүлж буй арьс ширний 23, ноос, ноолуурын 15, ариун цэврийн цаасны 5 үйлдвэрүүдэд хяналт шалгалт”-ыг 2014 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 04 дүгээр

сарын 10-ны хооронд Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар болон мэргэжлийн байгууллагатай хамтран явуулж, шалгалтын дүн тайланг НЗД-ын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнэ даргад хүргүүлээ.

- Согтууруулах ундааны үйлдвэрлэлд хяналт тавих ажлын хэсгийн ахлагч НЗД-ын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнэ даргын 2014 оны 05 дугаар сарын 05-ны өдөр баталсан удирдамжийн дагуу согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрлийн хугацааг зохих журмын дагуу сунгуулаагүй 11 үйлдвэрт холбогдох хууль, журмын хэрэгжилтийг шалгаж илэрсэн зөрчлийг арилгуулахаар, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, шалгалтын явцад гаргасан дүгнэлт, саналыг боловсруулж ҮХААЯам болон холбогдох газруудад хүргүүлж, шийдвэр гаргуулахад бэлэн болоод байна.
- ҮХААЯ, Ноос ноолуурын холбоотой хамтран 2011 онд Засгийн Газрын бондын хөрөнгөөс зээл авсан ноос ноолуурын үйлдвэрүүдэд үр дүнгийн шалгалтыг 2014 оны 9-р сарын 20-ноос 11-р сарын 05-ны хооронд явуулсан.

### ***3.2.9 Хотын хөгжлийн хэтийн төлөв, бодлогод тусгагдсан үйлдвэржүүлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэл, дүүргийн аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран ажиллах***

- Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/932 дугаар захирамжийн хүрээнд 2014 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Хангарьд ордны хурлын танхимд Нийслэлийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөны тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичигтэй уялдуулан салбарын хөгжлийн хэтийн төлөв, “Үйлдвэрлэл технологийн парк”-ийн талаар Нийслэлээс баримталж буй бодлогыг танилцуулах хурлыг зохион байгуулсан.
- Нийслэлийн ЗДТГ-ын Стратеги бодлого төлөвлөлтийн хэлтэс, Нийслэлийн Эдийн засгийн хөгжлийн газар, Улаанбаатар Бизнес Хөгжлийн Төв, Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо, үйлдвэрлэгчид болон Барилгын материалын үйлдвэрлэл технологийн паркийн ТЭЗҮ-г боловсруулж байгаа Арт констракшн ХХК-ны төлөөлөл оролцсон уулзалтыг зохион байгуулан ТЭЗҮ-ийн ажлын явц, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцсон.
- “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн парк”, Багануур дүүргийн Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд 2014 оны 11 сарын 4-ний өдөр ҮХААЯамны Хөнгөн үйлдвэрийн бодлого зохицуулалтын газрын орлогч, Арьс ширний үйлдвэрлэлийн холбоо, Багануур дүүргийн ТЭЗҮ хийсэн багийн ахлагч, Багануур дүүргийн газрын албаны дарга, Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэрлэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн болон холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөлөл оролцож 2015 оны НЭЗНЗорилтод орох саналыг танилцуулж, санал солилцсон.
- Үйлдвэрлэл, технологийн паркуудийн удирдлагуудад мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх, туршлага солилцох журмаар 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Оюутны хотхоны ашиглалтын өмнөх захиргааны дарга болон хуулийн зөвлөх буюу гэрээний мэргэжилтэн, Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дарга, Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны зөвлөх инженер, Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэрлэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэнүүд оролцсон уулзалтыг зохион байгуулсан.
- Налайх дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа шаврын орд ашиглах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах сургалтыг Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлал,



геологи, уул уурхайн хэлтэс, Дэд бүтцийн хяналтын хэлтэс, Санхүү, хөдөлмөр, нийгмийн хамгааллын хэлтэс, Нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газар, Нийслэлийн үйлдвэр, хөдөө аж ахуйн газар, Налайх дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс зэрэг байгууллагууд хамтран 2014 оны 03 дугаар сарын 12 –ны өдөр зохион байгуулсан. Сургалтанд Налайх дүүргийн нутаг дэвсгэрт тоосгоны үйлдвэрлэл эрхлэгч 28 аж ахуйн нэгжийн 35 төлөөлөл хамрагдлаа.

- “Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн анхдугаар зөвлөгөөн-2014”-ийг ЖДҮДТөвтэй хамтран 2014 оны 06 сарын 27-нд Нийслэлийн Иргэний танхимд зохион байгууллаа.
- НЗДТГ болон ШУТИС “Хамтран ажиллах санамж бичиг”-ийг зурахаар төслийг боловсруулж, бэлэн болголоо. Энэхүү ажлын хүрээнд дэд бүтэц, үйлдвэрлэл, мэдээллийн технологи, орчны бохирдол сэдэвт сэдэвчилсэн уулзалтуудыг 2014 оны 07 дугаар сард тус тус хамтран зохион байгуулж харилцан мэдээллийг солилцсон.
- Үндэсний үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчилах үзэсгэлэн худалдааг холбогдох газруудтай хамтран зохион байгууллаа:
  - “Монголд үйлдвэрлэв-Цагаан сар 2014” үзэсгэлэн худалдааг “Мишээл экспо” худалдааны төвд 1 дүгээр сарын 14-нөөс эхлэн 10 хоног, “Дүнжингарав” худалдааны төвд 1 дүгээр сарын 14-нөөс 14 хоногийн хугацаатайгаар 596 аж ахуйн нэгж, хувь хүнийг оролцуулан зохион байгууллаа. “Монголд үйлдвэрлэв-Цагаан сар 2014” үзэсгэлэн худалдааны явцад нийт 3,1 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь 2013 оны борлуулалттай харьцуулахад 1 аж ахуйн нэгжийн хоногийн борлуулалтын орлого 8 хувиар өссөн байна.
  - “Байгаль орчинд ээлтэй техник, технологи 2014” үзэсгэлэнд Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвтэй хамтран оролцов. Үзэсгэлэнд оролцсон аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд “Байгаль орчинд ээлтэй, техник, технологи-2014” хэлэлцүүлгийг зохион байгуулсан.
  - “Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи-2014” олон улсын үзэсгэлэн яармагийг ҮХААЯ, ХЯам, МҮХАҮТ-тай хамтран 2014 оны 06 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд Мишээл экспо төвд зохион байгуулсан. Үзэсгэлэнд Монгол, БНХАУ, Польш, Испани, ОХУ, ӨМӨЗО, Энэтхэг, Тайван улсын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй нийт 150 гаруй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид оролцсон. Үзэсгэлэнд хүнсний болон хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр 10 номинацид нийт 48 үйлдвэр, аж ахуйн нэгж нэрээ дэвшүүлэн өрсөлдөж “Шувуутайн гол” ХХК Гран при шагналыг хүртлээ.
  - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, МҮХАҮТ-ийн даргын 2014 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн хамтарсан А/878, А/879 тоот тушаал захирамжаар “Улаанбаатар Түншлэл-2014” Олон улсын үзэсгэлэн яармагийг 19 дэх жилдээ зохион байгууллаа. Уг үзэсгэлэнд гадаад дотоодын 100 гаруй аж ахуйн нэгж байгууллага, иргэн оролцлоо. Үзэсгэлэн яармагт амжилттай оролцсон 2 аж ахуйн нэгжийг Нийслэлийн Засаг даргын Өргөмжлөлөөр, “МҮХАҮТ”-ийн шагналаар 16 аж ахуйн нэгжүүдийг тус тус шагнаж урамшууллаа.

### ***3.2.11 Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд бизнес инкубацийн үйлчилгээг үзүүлэх, тэдгээрийг бойжуулах, хөнгөлөлттэй зээлд хамруулах ажлыг нийслэлийн холбогдох нэгжүүдээр дамжуулан гүйцэтгүүлэх***

- Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан байгуулах асуудлыг Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хурал, НИТТХ-аар тус тус хэлэлцүүлж дэмжигдлээ.

- Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хэрэгтэй хууль, эрх зүйн акт, тогтоол, шийдвэртэй холбоотой байнгын шинэчлэгдсэн мэдээллээр иргэдийг хангах, бизнес эрхлэхтэй холбоотой нийтлэг мэдлэгийг багцалсан сургалт зохион байгуулах, бусад бизнес эрхлэгчдийн талаар нээлттэй мэдээлэл өгөх, хамтран бизнес эрхлэх боломжийг олгох зэрэг ажлуудыг жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хүрээнд гүйцэтгэж байна.
- Нийслэлийн 9 дүүргийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвүүдэд эхний хагас жилийн байдлаар 3841 бойжигч бүртгэгдэж, 89 бойжигч байрлан үйл ажиллагаа явуулан инкубацийн үйлчилгээ авч байна. Мөн түүнчлэн 2525 хүнд зөвөлгөө мэдээлэл өгч, 57 удаа 1728 хүнийг сургалтанд хамруулж, 33 хэлэлцүүлэг зөвлөлгөөн уулзалт зохион байгууллаа.
- “Зээлийн батлан даалтын сан”-г нийслэл бие даан байгуулах талаар уулзалт ярилцлагыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Монголын банкны холбоо хамтран энэ оны 1 дүгээр улиралд зохион байгууллаа. Эрх зүйн үндэслэлийн хувьд “Зээлийн батлан даалтын сан”-г нийслэл бие даан байгуулах боломж хязгаарлагдмал тул нийслэлийн үйлдвэрлэл эрхлэгчдийг санхүүжилтээр дэмжих ажлын хүрээнд Улсын “Зээлийн батлан даалтын сан”-тай хамтран ажиллах “Гэрээ”, “Санамж бичиг” байгуулах талаар зөвшилцөн, “Хамтран ажиллах гэрээ”-ний төслийг боловсруулж, “Зээлийн батлан даалтын сан”-гийн удирдлагуудтай санал солилцон, харилцан зөвшилцөлд хүрээд байна. “Хамтран ажиллах гэрээ”-ний төслийг 2014 оны 05 дугаар сарын 14-ний Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн ба НИТХТ-ийн хуралдаанаар ЖДҮ-ийг дэмжих санхүүгийн эх үүсвэрийг хөнгөлөлттэй зээлд зарцуулахаар шийдвэрлэсэн тул энэхүү асуудал хойшлоод байна.

### **3.2.12 Малын үүлдэр угсааг сайжруулж ашиг шимийг нэмэгдүүлэхэд биотехнологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх ажлыг төрийн захиргааны төв болон салбарын шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран зохион байгуулах**

Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам сүүний үхрийн үүлдрийг сайжруулах, малын үржлийн ажлыг эрчимжүүлэх чиглэлээр Словак улсаас 10 мянган тун үрийг оруулж ирснээс эхний үе шатанд төвийн бүс болон нийслэл хотод үржүүлж буй сүүний үнээг хамруулахаар шийдвэрлэсний дагуу нийслэлийн 2000 үнээнд зохиомол хээлтүүлэг хийлгэх үрийн захиалга болон зардлын тооцоог боловсруулан Малын удмын сангийн үндэсний төвд хүргүүллээ. Малын удмын сангийн үндэсний төв, Чех улсын хөгжлийн агентлаг хамтран зохион байгуулсан “Бод малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх сургалт”-д Нийслэлийн 4 дүүргээс 9 мэргэжилтэнг хамрууллаа. Нийслэлийн хэмжээнд үнээний зохиомол хээлтүүлгийн явуулын 4 цэг ажиллаж, 120 үнээнд зохиомол хээлтүүлэг хийсэн дүн мэдээтэй байна.

Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2014 оны 05 сарын 01-ны өдрийн А/151 тоот тушаал, Нийслэлийн Засаг даргын А/708 тоот захирамжийн дагуу Нийслэлийн 8 дүүрэгт 31446 толгой сүүний болон хосолмол ашиг шимт үхэрт ангилалт хийлээ. Өндөр ашиг шимт сүүний үүлдрийн үнээ, сүргээ сайжруулсан фермийн малын чанарт үнэлгээ өгч, бүртгэлд авлаа. Мөн үхэр нэг бүрийн гено хэвшил, сүүн ашиг шим, бие цогцсын үнэлгээ, анги чанарын байдлыг батлагдсан маягтын дагуу тодорхойллоо. Ангилалтын дүнгээр цэвэр үүлдрийн хээлтэгч 30, хээлтүүлэгч 20 гаруй хувь, үүлдрээр сайжирсан нь 30 гаруй хувийг тус тус эзэлж байна.

Нийслэлийн Засаг даргын А/795 дугаар захирамжийн дагуу “Шилмэл мал-2014” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, үзэсгэлэнд нийслэлийн 6 дүүргийн 30 иргэн, 30 аж ахуйн нэгжийн 105 мал, амьтан оролцсоноос “Шилдэг номинаци”-ийн шагналд СХД-ийн иргэн Б.Төмөрбаатарын хар тарлан үнээ, “Шилмэл хээлтэгч”-ээр СХД-ийн иргэн



Д.Дагвацэрэнгийн хар тарлан үнээ, СХД-ийн иргэн 32-р хорооны Ч.Энхтуяагийн том цагаан үүлдрийн мэгж, “Шилмэл хээлтүүлэгч”-ээр БЗД-ийн иргэн А.Баярбаатарын алатау бух, БЗД-ийн 20-р хорооны иргэн Болдбаатарын иоркшир үүлдрийн бодон, “Тусгай байр”-ын шагналд ХУД-ийн иргэн Н.Баттөмөрийн хар алатау үнээ, “Түмэн шувуут” ХХК байгууллагаараа оролцон “Шилдэг оролцогч аж ахуйн нэгж”-ээр тус тус шалгарч гойд ашиг шимт мал, амьтанд бүртгэгдлээ.

"Хишигтэн нүүдэлчин" групптэй хамтран "Ферм-2014" шоуг 2014 оны 7 дугаар сарын 10,11-ны өдрүүдэд Хүй долоон худагт зохион байгууллаа.

### **3.2.13 Мал, тэжээвэр амьтны тэжээлийн үйлдвэрлэл эрхлэхийг бүх талаар дэмжиж ажиллах**

Нийслэлд үйл ажиллагаа эрхэлдэг тэжээлийн үйлдвэрийн судалгааг гаргалаа. Судалгаагаар нийслэлийн 7 дүүрэгт 10 аж ахуйн нэгж малын тэжээлийн үйлдвэрлэл явуулж байна. Үүнээс 5 аж ахуйн нэгж тэжээл тариалах талбайтай бөгөөд 8419,0 тн тэжээл үйлдвэрлэж хэрэглэгчдэд нийлүүлсэн байна. Алтан тариа ХХК үхэр, адуу, гахай, тахианы бүрэн найрлагат тэжээл хоногт 200 тонныг үйлдвэрлэж хэрэглэгчдэд нийлүүлсэн дүн мэдээтэй байлаа. Тэжээл үйлдвэрлэгчдийг дэмжих талаар Нийслэлийн “Монгол мал” дэд хөтөлбөрт тусган хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

### **3.2.14 Мал сүргийг индексжүүлж, им, тамгажуулах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах**

- Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санг баяжуулж, мал бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилт тавьж, энэ ажлын хүрээнд нийслэлийн мал, амьтан дамжин өнгөрүүлэх пост, захуудыг бүртгэл, мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбон ажиллах талаар холбогдох газруудын саналуудыг авч, "Монгол мал" дэд хөтөлбөрт тусган ажиллаж байна.
- Мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн 6 бүүрэгт мал эмнэлэг, үржлийн мэргэжлийн албыг байгуулах саналыг боловсруулж, салбарын яаманд хүргүүлээд байна.
- Мал бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн хэмжээнд нийт 106.300 малыг ээмэгжүүлж бүртгэлжүүлэн, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 30.000 малын мэдээллийг оруулж, баяжилт хийгээд байна.
- Бүртгэл мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбоход шаардлагатай санхүүжилтын саналыг боловсруулж, 2015 оны төсвийн төсөлд мал бүхий 6 дүүргийг мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох санхүүжилтийн асуудлыг тусган холбогдох газарт хүргүүлээд байна.

### **3.2.15 Усалгаатай газар тариаланг өргөжүүлэх ажиллагааг эрчимжүүлэх, хамгаалагдсан хөрсний /хучлагатай талбай, хүлэмж/ болон төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх**

- Шинээр ажлын байр бий болгох, хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Тарвагатайн аманд 35 га талбайд төмс, 720м<sup>2</sup> талбай бүхий 6 ширхэг хүлэмжинд хүнсний нарийн ногоо тариалж 700 иргэнийг хамруулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. 2010 оноос хойш “УБ аргопарк”-ийн төсөлд хамрагдан тасралтгүй, үр дүнтэй хүнсний ногоо тариалсан 12 бүлгийн 240 гишүүдэд 10700 ширхэг чацарганы суулгац зээлээр олгон 8,6 га талбайд тариалуулан, зааварчилгаа өглөө.

- Өвлийн хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулах төсөлд нийслэлээс 11 аж ахуй нэгж шалгарч хүлэмжийн барилгын ажлаа эхлүүлээд байна.
- ҮХААЯ-ны Тариалан эрхлэлтийг дэмжих сан, "World focus" ХХК, "Мөнх ногоон тал" ХХК, "Тот ком сервис" ХХК-тай хамтран "Хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, усалгааны технологи" сэдэвт үзүүлэн сургалтыг 2014 оны 04 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгуулсан. Танхимын сургалтанд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг 72 иргэн 10 аж ахуйн нэгж, талбайн сургалтанд нийт 200 гаруй иргэд тус тус хамрагдлаа.
- Үрслэг бойжуулах, хүлэмжинд хүнсний ногоо тариалах технологи", "Хөрс, түүний шинж чанар, тархалт, ашиглалт, сайжруулалт" сэдэвт сургалтуудыг 03, 04 дүгээр саруудад зохион байгуулж нийт 50 орчим иргэдийг хамруулан зохион байгууллаа.

**3.2.16 Өрх бүрийг хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах хөдөлгөөнд хамруулж, өрхийн тариаланг дэмжих зорилгоор төмс, хүнсний ногооны үр, үрслэг, жимсний суулгац, тарьцыг хөнгөлөлттэй үнэ болон зээлээр нийлүүлэх, суулгац үйлдвэрлэх санаачилгыг дэмжин туслах**

- Энэ оны хаврын тариалалтанд зориулан ҮХААЯ-аас шар лууван 54 кг, шар манжин 15.5 кг, хүрэн манжин 20 кг, бөөрөнхий сонгино 9 кг, урт сонгино 72 кг, төл сонгино 720 кг, ил талбайн өргөст хэмх 15 кг, хүлэмжийн өргөст хэмх 0,05 кг, далд хөрсний лооль 0,45 кг нийт 907 кг хүнсний ногооны үрийг 9 дүүргийн ЗДТГ болон 10 аж ахуй байгууллага, 150 гаруй иргэнд олгож, тариалах зааварчилгаа өгч ажиллалаа.
- "Чацаргана" хөтөлбөрт хамрагдаж 2011-2014 онуудад чацарганы суулгац зээлээр авсан материалыг үндэслэн ургамал хамгааллын болон таримлын нэр төрөл агротехник, тариалалтын байдалтай газар дээр нь танилцаж, заавар зөвлөгөө өгч, гарын авлага ном материалыг олголоо. 2014 онд 42 иргэн, 13 аж ахуйн нэгжид 134025 ширхэг суулгацыг хүүгүй зээлээр олгон 107,2 га талбайд тариалууллаа.
- "Чацаргана бусад жимс, жимсгэнэ тарьж ургуулах, технологи", "Гүзээлзгэнэ тариалах технологи", чацаргана бусад жимс жимсгэнэ тариалагчидад сонирхогчдод зориулсан анхан шатны сургалтуудыг 04 дүгээр сард тус тус зохион байгуулж, 200 орчим иргэн, аж ахуйн нэгжийг хамрууллаа.
- Нийслэл хотын орчимд "Чацаргана, үхрийн нүд, гүзээлзгэнэ тарьж ургуулах арга, технологи" товхимлыг 500 ширхэг хэвлүүлж, тариаланч өрх, аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлэн гарын авлага болгон ашиглаж байна.
- Ерөнхий сайдын 100 дугаар захирамжийн дагуу нийслэлийн 5 дүүрэгт шинэ ургацын ногоог хямд үнэтэйгээр борлуулах худалдааны сүлжээ болгох чиглэлээр тавигдсан төвлөрсөн 6 цэг, худалдааны 19 павилонуудын бүрэн бүтэн байдал тэдгээрийн байршил, худалдаа хийх ногоочдын бүртгэл, цаашид үйл ажиллагааг жигдрүүлэн жилийн 4 улиралд төмс, хүнсний ногоог талбайн түрээсгүйгээр борлуулах, эко ажлын байраар хангах зорилготойгоор ажиллаж байна.
- Нийслэлийн тариаланчид 2014 онд төмс 393га талбайд тариалж 5692 тонн, хүнсний ногоо 392 га талбайд тариалж, 6603 тонн ургац хураан авсан нь нийслэлийн хүн амын төмсний хангамжийн 8,8%-ийг, хүнсний ногооны 7,3%-ийг хангасан байна.

- “Нийслэлийн тэргүүний тариаланч”, “Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон”-ы материалыг дүүргүүдээр дамжуулан хүлээн авч, НИТХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлээ. 2013 онд нийслэлийн газар тариалангийн салбарт амжилт гарган ажилласан Хан-Уул дүүргийн 13-р хороо “Баялаг жимс” ХХК, Баянгол дүүргийн 20-р хороо “Сэнжит Оюу” ХХК-ыг “Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон”-оор, Налайх дүүргийн 4-р хорооны тариаланч А.Мундзарь, Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны тариаланч Ч.Даваа, Хан-уул дүүргийн 13-р хорооны тариаланч Д.Баатарзул нарыг “Нийслэлийн тэргүүний тариаланч”-аар шалгаруулан энгэрийн тэмдэг, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.

### **3.2.17 Байгаль орчин, бүтээгдэхүүний чанарт сөрөг нөлөөгүй аргаар тариалангийн хог ургамал, өвчин, хортон шавьж, мэргэчидтэй тэмцэх арга ажиллагааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах**

- “Ургамал хамгааллын бодисыг зөв зохистой хэрэглэх нь” сэдэвт сургалтыг тариалалтын талбайд зохион байгуулж, 8 дүүргийн 120 гаруй тариаланчдад хог, ургамал, өвчин хортонтой тэмцэх аргуудын заавар зөвлөгөө өгсөн.
- УМХЕГ болон НМХГ-тай хамтарсан шалгалтыг 2014 оны 04 дүгээр сарын 21-нээс 05 дугаар сарын 06-ны өдрүүдэд хийж нийслэлийн 4 дүүргийн 41 зоорины ашиглалт, хадгалагдаж буй үрийн төмсний хадгалалт, борлуулалтанд хяналт тавин, зөвлөгөө өгч ажиллалаа.
- 2014 оны 8, 9 сард 2 үе шаттайгаар ҮХААЯам болон Дархан-Уул аймгийн УГТЭШХүрээлэнгээс хамтран зохион байгуулсан тогтвортой хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд “Ургамал хамгааллын цогцолбор аргыг хэрэглэх” сэдэвт агрономичдын сургалтанд Газар тариалангийн хэлтсийн 2 мэргэжилтэн хамрагдсан.

## **Тав. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал**

### 5.1. Үйл ажиллагааны ил тод байдал

Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай НЗД-ын 2012 оны 606 дугаар захирамжийн дагуу байгууллагын цахим хуудсанд дараах мэдээллүүдийг байршууллаа. Үүнд:

- Газрын даргын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гарсан тушаал
- Байгууллагын танилцуулга
- Байгууллагын бүтцийн схем
- Байгууллагын албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг, холбоо барих утас, цахим хаяг
- Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм
- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм
- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны ёс зүйн дүрэм
- Байгууллагын 2013 оны төсвийн гүйцэтгэл
- 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт
- 2014 оны жилийн төсөв
- 2014 оны төсвийн сүүлийн хагас жилийн гүйцэтгэл /сараар/
- 2014 оны төсвийн төсөл
- Үзэсгэлэн худалдааны болон худалдан авах үйл ажиллагааны зар мэдээлэл болон тайлан

- Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа МУ-ын Засгийн Газрын 2010 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан жилд 2 удаа явуулдаг “Чацаргана” төслийн шалгаруулалтын зар, мэдээлэл болон тайлан
- Жил бүрийн сар шинийн баярыг тохиолдуулан ХАА-н салбарт үр бүтээлтэй ажиллаж буй тариаланч, малчдыг шалгаруулах НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 183 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон”, “Нийслэлийн тэргүүний тариаланч”, “Нийслэлийн тэргүүний фермер” журам, материал ирүүлэх зар, бүрдүүлэх материалын жагсаалт
- Байгууллагын хүрээнд зохион байгуулагдаж буй дотоод ажлын мэдээ, мэдээлэл

“Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор байгууллагаас иргэд, хуулийн этгээдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд “UBLEGAL.MN” цахим хуудсанд 1993-2014 онд байгууллагаас гарсан захирамжлын баримт бичгийг орууллаа.

## 5.2. Хүний нөөцийн ил тод байдал

- Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/120 дугаар захирамжийг үндэслэн газрын даргын 2014 оны Б/05 дугаар тушаалаар 8 албан хаагчдад зэрэг дэвийн нэмэгдлийг олгож байна.
- Байгууллагын хүний хөгжлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, тайланг НЗДТГ-т хүргүүлсэн.
- Байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулж, оролцох боломжийг хангаснаар албан хаагч дотоод, гадаадын сургалтанд хамрагдлаа. Сургалтанд хамрагдсанаар мэргэжилтнүүдийн ур чадвар дээшилж байна.
  - Удирдлагын Хөгжлийн Академид 1 албан хаагч Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах болзлыг ханган суралцаж байна.
  - Байгууллагын албан хаагчдыг хуваарилан Нийслэлийн архивын газрын "Архив, албан хэрэг хөтлөлт"-ийн сургалтад 14 мэргэжилтэн, Худалдан авах ажиллагааны сургалтад 6 мэргэжилтэн, Мэдээлэл технологи, IT-сургалтад Б.Сайнбаярыг тус тус хамрууллаа.
  - "Хөрс ургамал хамгаалал, хортон шавжтай тэмцэх" сэдвээр С.Гочоосүрэнг 10 өдрийн сургалт, "Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний тэнцэл тооцох" 3 өдрийн сургалт А.Цэцгээ, НМЭГ болон залуу малчдын зөвлөгөөнд ЭМААхэлтсийн бүх мэргэжилтэн тус тус оролцлоо.
  - Мөн ЭМААХ-ийн мэргэжилтэн О.Батжаргал, Д.Сугармаа нарыг бүртгэлийн програм болон малын эмчийн сертификаттай сургалтанд хамруулав.
  - Англи хэлний сургалтыг байгууллагын дотоод нөөцөд тулгуурлан зохион байгуулж, сургалтанд 10 албан хаагч хамрагдаж байна.
  - Монгол хэлбичгийн ур чадварыг дээшлүүлэх хүрээнд Монгол хэлбичгийн олон хувилбар бичлэгт 700 монгол үгийг журамласан жагсаалтыг бүх албан хаагчдад танилцуулан, мөрдүүлж байна.
  - Байгууллагын хэмжээнд Архивын стандартчиллын сургалт, Авилгатай тэмцэх газраас зохион байгуулсан Хууль сахих ач холбогдол, ХАСХОМ болон түүнийг үнэн зөв гаргаж өгөх сэдэвт сургалт, Удирдлагын академаас захиалсан ТАХ-ийн ёс зүйн сургалт, мөн эрүүл мэндийн сургалтуудыг тус тус зохион байгуулж, бүх албан хаагчдыг хамрууллаа.

- 2014 оны төсвийн зохицуулалтыг хийж, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлыг 4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын дагуу албан хаагчдад болон ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан өндөр настанд буцалтгүй тусламжинд даргын тушаалаар нийт 7,897,770 төгрөг зарцууллаа.
- Байгууллагын албан хаагчдыг хөдөлгөөний хомсдол, чимээгүй халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын спортын хамтлагийг байгуулж, 7 хоног бүрийн 1 дэх өдөр спорт зааланд тоглох боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн байгууллагын спорт, урлагийн аварга шалгаруулах арга хэмжээ, “Эрүүл мэндийн аян”-ыг тус тус зохион байгууллаа.

### **Зургаа. Шинэ санаачилга, үр дүн**

- Хот орчмын бүсэд мал аж ахуйг эрчимжсэн хэлбэрээр хөгжүүлэхэд хадлан бэлчээрийн талбайн ургамлын нөмрөгт цөлжилтийн даацыг даахуйц, орчны таатай уур амьсгал бүрэлдүүлэх, хөрс цаг уурын нөхцөлд тохирсон ургах чадвар өндөр ногоон масс ихтэй тэжээлийн ургамлыг нутагшуулж, малчид, фермерүүдийн идэвхи оролцоонд тулгуурлан бэлчээрийн менежментийг шинэчлэх зорилготойгоор “Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” төслийн хөтөлбөрийг боловсрууллаа. Хөтөлбөр нь үндсэн 4 зорилттой, 1 үе шаттай 2014-2020 онд хэрэгжихээр төлөвлөгдөөд байна. Хөтөлбөрийг Баянзүрх дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэр Улиастайн амны эхэнд байрлах Баянголын ам, Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Нарийны хөндийн Хадатын зүүн амыг сонгож хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Хөтөлбөрийн бүтэц зохион байгуулалт, шаардагдах хөрөнгө оруулалтын төсвийг төслийн хамт Нийслэлийн ИТХуралд өргөн бариад байна.
- Мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа малчдын нийгэмд оруулж байгаа хувь нэмрийг үнэлж, тэднийг урамшуулах, уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгон малын ашиг шимийн гарц, чанарыг сайжруулах, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор “Нийслэлийн тэргүүний фермер”, шалгаруулах журамд өөрчлөлт оруулахаар, “Нийслэлийн сайн малчин” шалгаруулах журмыг шинэчлэн боловсруулж, тогтоолын төслийг удирдлагуудад танилцуулан, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралд хэлэлцүүлэн батлуулав.

### **Долоо. Хэрэглэгчийн үнэлгээ**

2014 онд үндсэн ажил үйлчилгээний чиг хандлагыг тусгасан 4 асуулт бүхий хуудсыг шинэчлэн боловсруулж үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгж байгуулагуудаас нийт 304 санал ирүүлсэн байна.

Иргэдийн өгсөн санал, гомдлыг харахад иргэдийн дийлэнх хувь буюу 54% нь хэлтсүүдийн үйл ажиллагааг сайжруулах, 15% энэ чиглэлийн сургалт авах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн бол 22% нь, мэдээллийг хүртээмжтэй, түргэн шуурхай авах, төсөв хөтөлбөрт хамрагдах саналтай байна. Харин дүүргийн боловсон хүчнийг чадваржуулах, зээл авах хүсэлтэй иргэд цөөнгүй байгааг мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих талаар санаачлагатай ажиллах шаардлагатайг судалгааны дүн харуулж байна.

Байгууллагын цахим хуудсыг шинэчлэн ажиллуулж эхэлснээс хойш нийт 5188 хүн зочилж байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг авсан байна. Нийт 65 хүн

байгууллагын үйл ажиллагааны талаар санал өгсөнөөс 51% маш сайн, 22% нь хангалттай, 18% хангалтгүй үнэлгээг өгсөн байна.

ТАЙЛАН ХЯНАСАН:  
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

Д.МЯГМАРСҮРЭН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Р.УНДАРМАА